

МОНГОЛ УЛСЫН ГУРАВ ДАХЬ ХӨРШ ХИЙГЭЭД ТҮНШИЙН АСУУДАЛД

**МУИС, ОУХС-ийн тэргүүлэх
профессор, доктор (Ph.D) Ж.Баясах**

Монгол улс БНХАУ хийгээд ОХУ-тай хил залгадаг. XVII зуунд Оросууд Сибирийг эзэмших болсноор Орос улстай манай улс хил залгах болж умарт хөрштэй болсон түүхтэй. Харин БНХАУ-ын нутаг дээр байсан эртний улсуудтай МЭӨ 2 дахь мянган жилээс нааш хиллэж иржээ. Түүхэн хөгжлийн урт хугацаанд Монгол улс хөгжил буурал, нэгдэл бутралын аль алиныг даван туулж өнөөг хүрсэн. Эл үйл явцын үр хөврөлөөр Монголын нутаг дэвсгэр нэг үе тэлж, нэг үе агшиж ирсний дээр хүчирхэг байх ахуйд хүчээр түрий барьж өөрийн болзлыг тулган улс төр, эдийн засгийн ашиг олж байсан бол улс орон доройтож нэгдэлгүй болсон үедээ хоёр хөршийн шахалтанд орж байлаа.

Цаашид Монгол улс хөгжлийн шинэ шатанд гарахын тулд хоёр хөрштэйгээ харилцаагаа улам бүр ашигтай хөгжүүлэхээс гадна гурав дахь хөрш буюу түншлэгчээ зөв сонгох явдал туйлын чухал болно. Иймд хөрш хийгээд түншийн талаар энэхүү өгүүлэлдээ өгүүлсүгэй.

Монгол, Орос, Хятад хөрш улсууд өнгөрсөн зуунд

Өнгөрсөн зуунд Монголын түүхэнд асар их өөрчлөлт гарч 1911 онд тусгаар тогтнолоо сэргээж авсан ч түүнээ алдаж 1921 онд Ардын засаг тогтсоноор дахин сэргэн 1924 онд Бүгд Найрамдах Улс болж, 1992 онд улсаа шинэ Үндсэн хуулиар Монгол улс хэмээх болж парламентын засаглалтай олон намын тогтолцоотой, зах зээлийн эдийн засагтай, хүмүүнлэг ардчилсан улс байгуулах болсон.

Өөрөөр хэлбэл 1911 онд Олноо өргөгдсөн хаант улс байгуулж, улмаар 1924-1990 онд капиталист бус хөгжлийн замыг сонгон тоталитар дэглэм бүхий социалист улс байгуулахаар замнаж байснаа "Хүйтэн дайн"-ы үе төгсмөгц ардчилсан улс цогцлон байгуулахаар болжээ.

Эл хугацаанд 1990 он хүртэл Хаант Орос, улмаар ЗХУ-ыг хэт дагаж социализмын 70 жилд үнэндээ Зөвлөлтийн Бүгд Найрамдах Улсаас төдийлөн ялгагдахааргүй нэг улсын "дагуул" улс болж түүний хүчтэй нөлөөнд автаж үндэсний бахархал түүх юүгээн уландаа гишгэж коммунист үзэл суртлыг өрөөсгөлөөр мулгуу дагасан хэт үзэл сурталжсан тоталитар улс байснаа 80-аад оны сүүлчээр Дорнод хийгээд Төв Европт өрнөсөн ардчиллын нөлөөгөөр жинхэнэ тусгаар байдлаа олсон үндэсний үзэл хүчтэй өрнөсөн дэлхийн жишгээр ардчиллыг тогтоосон улс болж шилжилтийн үедээ явна.

БНМАУ-ын үед Монгол орон Азийн орон гэхээсээ илүү Москваг тойрсон "дорнодын эвсэл"-ийн орны нэг болж гадаад ертөнцөөс тасарч дэлхийд үл танигдах алслагдсан, мөн мартагдсан улс болсон. Өнгөрсөн хугацаанд улс орны хөгжилд зарим дэвшилт гарсан хэдий ч 3 түм гаруй тэргүүний сэхээтнээ хэлмэгдүүлж, бичиг үсэг, шашин шүтлэгээ талхидан хаяж бүхнийг Зөвлөлтөөс хуулж хөөрхий байдалд орсон. Гадаад бодлогын хувьд эхэн үедээ Коминтерн, Москвагийн шууд заавраар ажиллаж, дэлхийн II дайны дараа дэлхийд "хоёр туйлт" тогтолцоо тогтоход "пролетарийн интернационализм" гэж хийрхсэн "дорнодын эвсэл" дэх ядмаг айл болж зөвхөн 1949-1962 оны хооронд БНХАУ-тай нэг үе ойртож, "Хятадын соёлын хувьсгал"-аас улбаатай Зөвлөлт-Хятадын харилцаа муудаж нэг хэсэг холдож, улмаар 1985 оноос хоёр хөршийн харилцаа "перестройка"-гийн уур амьсгалаар бүлээрэхүйд өмнөт хөрштэйгээ харилцаагаа сэргээх болсон.

Дүгнэн өгүүлбээс, XX зуунд Монгол улс гадаад ертөнцөөс тасархай, зөвхөн умарт хөрш, цаашлаад Дорнод Европын социалист гэгдэж байсан улсуудтай явцуу харилцаатай байсан агаад өмнөд хөршөөсөө, мөн бүхий л Азийн улс орнуудаас ерөнхийдөө хөндий харилцаж ирсэн байна. Зөвхөн 90-ээд оноос Монгол улс Азийн улс болохоо гэнэт ардчилсан үйл явцын ачаар ухаарч "тусгаар тогтнолоо" жинхэнэ утгаар нь олж анх удаа 1994 онд "Гадаад бодлогын үзэл баримтлал" хийгээд "Монгол улсын аюулгүй байдлын үзэл баримтлал" төргийг батлан гаргаж гадаад бодлогодоо мөрдөх болсноор ОХУ хийгээд БНХАУ-тай тэгш харилцах болсны дээр хоёр хөрштэйгөө харилцах явдлыг гадаад бодлогынхоо "тэргүүлэх чиглэл" болгон зарласан болно. Өөрөөр хэлбэл нэг улсын "хараат" байхаа больж БНХАУ-ыг хүндэтгэн үзэх болж, ОХУ-тай ижил түвшинд харилцах болсноо тунхаглан зарласан зэрэг мөн.

Монгол улс шинэ гадаад орчинд

Дэлхийн II дайнаас хойш үргэлжилсэн "хүйтэн дайн" 1990 онд Берлиний ханыг нурааж, улмаар ЗХУ задран унаснаар дууссан юм. Эл үе дууссанаар дэлхийд "хоёр туйл" үгүй болж, "олон туйл" буй болсон. Гэтэл Монгол улсын хоёр хөрш "нэг улсын ноёрхол" (юнитаризм) дэлхийд тогтсон хэмээж буй нь АНУ-ыг хэлж байгаа нь одоо нэгэнтээ хэнд ч тогтогдох болов. Монгол улсын хувьд "олон туйл"-ын дэг журам, тогтолцоо дэлхийд тогтсон нь шинэ гадаад орчинтой болоход таатай зүйл болсон хэмээн үзүүштэй¹.

Монгол улс дэлхийд шинэ дэг журам тогтмогц өөрийн улсаа Зүүн Азийн орон болохоо мэдэгдсэн. Бид өмнө нь өөрсдийгөө Төв Азийн орон гэдэг байсан нь гадаад хэлэнд, ялангуяа англи хэлнээ буухад "Central Asia" гэдэг ойлголт өгч байсан явдал гадаадын нөхдийн хувьд Дундад

¹ Үүнийг харах, "XXI зуун хийгээд глобалчлалын асуудал", "Шинэ толь" сэтгүүл, 2000, №30, 115-р тал

Азийн шинэ тусгаар тогтносон 5 улс (Узбекистан, Казакстан, Киргизстан, Туркменистан, Таджикистан)-тай будлихад хүргэх болсон. Иймд газар зүйн байрлалаа зөв тодорхойлох үүднээс бид өөрсдийгөө "Central Asian country" гэж байснаас татгалзахад хүрч "North East Asian country" хэмээн томьёолох болсон. Ингээд Япон, хоёр Солонгос, Оросын Алс Дорнод, Хятадын зүүн хойт 3 муж (Хармөрөн, Гирин, Ляонин)-ийн нэгэн адил бид Зүүн хойт Азид багтах болсон. Энэ нь нэгдүгээрт, монголчууд бид эл бүс нутагт багтах нь улс орны цаашдын хөгжилд дөхөм болно гэдгээс улбаатай буюу, хоёрдугаарт, эл бүс нутгийн хөгжил улам бүр хүчээ авч улам интеграцчилагдаж байгаа нь нөлөөлсөн ажгуу.

Ийнхүү хоёр хөршөөс гадна Япон, БНАСАУ, БНСУ зэрэг улсууд, өрнө зүгт Европын холбооны улсууд, АНУ, Канад, АСЕАН-ы орнууд хийгээд Австрали, Шинэ Зеланд ч манай шинэ гадаад орчныг бүрдүүлэх болов. Эл байдлаас үүдэн манай гадаад харилцаа зөвхөн ОХУ хийгээд БНХАУ-ын босоо тэнхлэгээр бус мөн өрнө зүгт Европын Холбоо, уламжлалт харилцаатай Төв хийгээд Дорнод Европын орнууд (Чех, Польш, Унгар, Болгар, Словак, хуучин Югаславын бүрэлдэхүүний улсууд, дорно зүгт Япон, БНАСАУ, БНСУ, Америк, Канад, АСЕАН-ы улсууд г.м багтаасан Ази Номхон Далайг хамран үргэлжлэх хэвтээ тэнхлэгээр хөгжих болсон гэж үзүүштэй. Өөрөөр хэлбэл шинэ Монгол улс харилцаагаа цоо шинэ нөхцөлд, гадаад орчинд хөгжүүлэх боломжтой болсноор дүр зураг өөр болов.

Монгол улс ардчилсан орон болсон, дэлхийд шинэ дэг журам тогтсон зэргээс гадаад гүрнүүдтэй харилцах харилцаанд асар том өөрчлөлт гарч тус улсад гадаадаас үзүүлэх тусламж нэмэгдэж ирсний дүнд өнгөрсөн 10 жилд бараг 1 тэрбум америк долларын зээл, тусламж зэргийг олгосон байна.

Дүгнэн өгүүлбээс сүүлийн 10 жилийн дотор Монгол улс зөвхөн ЗХУ хийгээд дорнодын Европын орнуудыг шүтсэн гадаад бодлогоо бүрмөсөн өөрчилж, шинэ гадаад орчинд шинэ гадаад харилцаагаа хөгжүүлэх боллоо.

Монгол улсын гурав дахь хөрш АНУ мөн үү?

1990 онд Персийн буланд дайны гал дүрэлзэхийн урьд өдөр АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бейкер Монгол улсад айлчилсан билээ. Эл айлчлал нь 1944 онд АНУ-ын дэд ерөнхийлөгч Хенри Уоллес манайд айлчлал хийснээс хойшхи анхны дээд хэмжээний айлчлал болсноороо онцлог. Ж.Бейкер Монголын шинэ эрх баригчидтай уулзах үедээ "АНУ бол Монгол улсын гурав дахь хөрш" хэмээн албан бус яриандаа өгүүлснээс хойш манай улс төрчдийн дунд үнэхээр бид АНУ-ын хөрш хэмээн үзэх явдал их болсон. Мөнхүү айлчлалын ид дунд Кувейт-Иракийн хооронд дайн гарсан бөгөөд Монгол улс АНУ-тай хамт уг дайныг эсэргүүцсэн мэдэгдэл гаргасан. Ийнхүү Монгол улс ноён Ж.Бэйкерийн ачаар олон улсын томоохон мөргөлдөөнийг эсэргүүцсэн түүхтэй. Ер нь ноён Ж.Бэйкер Монголд хоёр удаа албан ёсоор айлчилсан

явдал бол Монголд өрнөсөн ардчилсан үйл явцыг АНУ дэлхийн олон нийтийн өмнө дэмжиж буйгаа харуулснаараа онцлог. Тэрээр 1996 онд Монголын ГХЯ-ны урилгаар Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалаа өгснөөс хойш манайд дахин айлчилсан.

Дараа нь 1995 оны 9-р сард АНУ-ын тэргүүн хатагтай Хиллари Клинтон, мөн 1998 оны 5-р сард Төрийн нарийн бичгийн дарга Мадлен Олбрайт Монголд тус тус айлчилсан билээ. Одоогийн байдлаар энэ оны 10-р сард АНУ-ын ерөнхийлөгч Ж.Буш БНХАУ-д айлчлахын өмнө хойно аль нэг өдөр Монгол улсад айлчилж магадгүй хэмээн гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгсэл саяхан мэдээлсэн. Хэрэв уг айлчлал ёсчлон бүтвэл АНУ-ын Монголд хийсэн хамгийн дээд хэмжээний айлчлал болох юм. Гэхдээ өнөөдөр үүнийг хэрэгжүүлэхийн төлөө манай болон америкийн дипломатууд багагүй ажиллах нь мэдээж билээ.

Америкийн хувьд Монгол улс хоёр цөмийн зэвсэгтэй их гүрний дунд оршдог газарзүйн байрлал нь геостратегийн үүднээс онцгой анхаарал татаж байгаа учир ардчиллаж яваа парламентын засаглалтай Монгол улсыг өнгөрсөн 10 жилд дэмжиж ирсэн бөгөөд саяхан Ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхий сайд Н.Энхбаяр нарт өөрийг нь Ерөнхийлөгч болсонд баяр хүргэсэн цахилгаан утасны хариуд талархаж Ж.Буш "АНУ Монгол улсын ардчилсан үйл явцыг дэмжиж ирсэн, цаашид ч дэмжих болно" хэмээн мэдэгдээ.²

Дээр өгүүлснийг дүгнэвээс: үнэхээр сүүлийн 10 жилд АНУ Монгол улсыг улс төр, эдийн засгийн талаар дэмжиж ирсэн бөгөөд бусад хөгжингүй орнуудыг уриалан дуудсаны ачаар бид АНУ-тай "худалдаа хийх таатай нөхцөл" олж, ГАТТ, Дэлхийн Худалдааны Байгууллага, АРФ зэрэг олон улсын байгууллагад гишүүнээр элсэн, мөн Дэлхийн банк, Олон улсын Валютын Сан, Азийн Хөгжлийн Банк зэргээс урт богино хугацааны зээл тусламж авч ирсэн ч АНУ Монголд том хөрөнгө оруулалт хийгээгүй, өөрийн хил дамнасан корпорацийн салбараа нээгээгүй зэргийг бодоход л "Энэ улс манай улсын гурав дахь хөрш" хэмээн үзвээс туйлын гэнэн явдал буюу.

Олон улсын байгууллагууд хийгээд Монгол улс

Олон улсын харилцааны онолд "nation" (үндэстэн), "nation state" (улс үндэстэн), "state" (улс), "international organizations" (олон улсын байгууллагууд), "transnational corporations" (хил дамнасан корпорациуд)³ нь олон улсын харилцааны "actor" буюу "оролцон тоглогч"³ болдог. Ердөө хоёр хөрштэй Монгол улсын хувьд "олон улсын байгууллагууд", эсвэл "хил дамнасан корпорациуд"-ын аль нэг нь "түнийн" болох учиртай.

Өнөөдөр хил дамнасан корпорациудын хөрөнгө оруулалт, худалдааны эргэлт, хөрөнгө мөнгөний чадавхи нь бүх дэлхийн ижил

² "Зууны мэдээ", 2001.4.3, №77

³ "Contemporary International Relation," Daniel S.Papp, New York-London, 1998, pp.17-20

чиглэлийн үйл ажиллагаа, чадавхиас үлэмж давжээ. Иймд дэлхийн цаашдын хөгжлийг ХДК-ууд тодорхойлох болно. Мөн ХДК-уудын нэг улс хийгээд бүс нутагт үзүүлэх нөлөө үлэмж их байх ажээ. Гэтэл Монголд мөнхүү корпорациудын аль нэг нь ч хөлөө тавиагүй байгаа тул тэдгээр нь манай улсын хувьд "түнш" биш болох юм.

Олон улсын байгууллагуудаас хамгийн олон гишүүн улстай байгууллага бол Нэгдсэн Үндэстний Байгууллага мөн. Монгол улс уг байгууллагад элсэхээр аль 1946 онд хүсэлтээ гаргасан авч 1961 оны 10-р сард элссэн. НҮБ-ын гишүүн болсноос хойш өнөөг болтол бид 160 сая ам. долларын тусламж өнгөрсөн 40 жилд авчээ. Тусламжийг олон жижиг төслөөр дамжуулж авсан тул Монгол улсыг хөл дээр нь босгоогүй юм. Эл тусламжийн хэмжээ нь өнөөдрийн Монгол улсын жилийн төсвийн хэмжээнд ч хүрэхгүй байгаа тул тун чамламаар нь ойлгомжтой. Мөн өнгөрөгч хугацаанд бид НҮБ-ын гишүүний татварт багагүй мөнгө төлжээ.

Дэлхийд өөр олон байгууллагууд байдгаас 15 том эдийн засгийн интеграцчилагдсан байгууллага буй. Үр өгөөжтэй заримыг нь дурдвал Европын Холбоо, Дэлхийн Банк, Олон улсын Валютын Сан зэрэг юм. Эдгээр байгууллагаас ардчиллаар замнасан 10 жилд бид НҮБ-аас 40 жил авч байснаас илүү тусламж хүртлээ. Гэхдээ мөн л чамлахаар байдаг. Иймд Монгол улсын хувьд "ОУБ" ч, мөн "ХДК" ч тэр "гурав дахь түнш" нь биш байна.

"Соёл иргэншил" хийгээд Монгол улсын ирээдүй

Өнөөдөр олон улсын харилцааны онолчид аливаа улс, "actor"-оролцон тоглогчоос илүү дэлхийн цаашдын хөгжлийг үзэл суртал ч биш, эдийн засаг ч бус, харин соёл иргэншил тодорхойлно хэмээн үзэх болжээ.⁴ Иймд манай нүүдлийн соёл иргэншил маань бидний цаашдын хөгжлийг тодорхойлох юм биш байгаа гэсэн асуулт зайлшгүй урган гарна.

Өнөөдөр дэлхийн нийт 6 тэрбум хүн амын аравны нэг нь нүүдлийн соёл иргэншилтэй хэмээн бичдэг. Тэгвэл тэдгээр нүүдэлчдээс дэлхийн түүхэнд аль үндэстэн ул мөрөө тод үлдээсэн бэ хэмээвэл монголчууд юм.

Монголчууд дэлхийг бараг 250 жил их бага хэмжээгээр донсолгож өөрийн эрхшээлдээ байлгажээ. Мөн биднийг эзэн Чингис хаанаас Хубилай хаанаар дуустал бараг 100 жил дэлхийн талыг эзэгнэж байсан гэдэг. Эл үе маань XIII-XIV зуун юм. Монголчууд яагаад ийм агуу их хүчтэй байв гэдгийг үе үеийн гадаад дотоодын эрдэмтэд толгойгоо эргэтэл судалсан авч цэрэг-улс төрийн нарийн зохион байгуулалттай байснаас их амжилтанд хүрсэн гэдэг үзэл давамгайлна. Саяхнаас манайхан түүхээ өөрөөр ухаарч зөвхөн цэрэг улс төрийн чадавхиас гадна бид илүү соёл иргэншилтэй байжээ гэж дүгнэж бахархах болсон. Тиймээ, дундад зууны тэр үед нүүдлийн соёл иргэншил суурин газрын соёлоос илүү байсан. Тухайн үед суурин газрууд ган гачиг, дайн самуун, далайн тээвэр хөгжөөгүй байсны гачааллаас болоод эд агуурсын хувьд, мөн оюун

⁴ S.Huntington, "The Crash of Civilizations", "Foreign Affairs", Summer 1993.

санааны хувьд уналтанд ороод байсны улмаас Монголын аравтын зохион байгуулалт, хурдан шалмаг тактик, орчноо үнэлдэг ухаан, нүүдэлчдийн оюун ухаанд дийлдэж бидний ноёрхолд байсан.

Гэтэл өнөөдөр суурин газрын соёл, оюун ухааны нээлт зэрэг нь нүүдэлчдээс асар илүү хурдацтай хөгжив. Суурин газрын соёл иргэншлийг Өрнөдийн, Хиндугийн, Хятадын, Японы, Еврейн (Жүдийн), Орос-Славын гэх мэтээр ангилдаг.⁵ Эдгээрээс илүү дэвшилтэй нь мэдээж өрнөдийн соёл иргэншил ажээ.

Өрнөдийн соёл иргэншилтэй орнууд, тухайлбал нөгөө хүчирхэг 7 гүрэн гэх мэт улсууд дэлхийн хөгжлийг тодорхойлж байна. Газар зүйн хувьд тэдгээр улсууд Өрнөд Европ, Умарт Америкт орших ажээ. Эдгээр улсуудаас эдийн засаг, улс төр, зэр зэвсэг, боловсролын түвшингээр, мөн олон улсын "ноёрхогч" байдлаараа АНУ л тодорно.

Өрнөдийн соёл иргэншил, улс төрд ардчилсан үзэл санаа, Үндсэн хууль, парламентын засаглал, хувь хүний эрх, эрх чөлөө, чөлөөт хэвлэл, хүний эрхийг эрхэмлэх ухааныг авчирсан билээ. Иймээс эдгээрийг хэрэгжүүлж ирсэн улс гүрнүүд хөгжингүй болж бусдын соёл иргэншлийг хөлдөө чирж байна.

Монголчууд бид цаашид улам хөгжихийн тул өрнөдийн соёл иргэншлийг дээдлэн өөрсдийн соёлын сорыг аваад хослуулбал сая "гурав дахь түнш" хайлгүйгээр хөгжих болно.

Дүгнэлт

Нэгдүгээрт: Монголын цаашдын хөгжилд хоёр их гүрэн хөрштэйгээ эрх тэгш харилцаж, "аливаа эвсэлд үл нэгдэх" явдал чухал. Гэхдээ хоёр хөрш маань тогтвортой хөгжвөл бид тэдний "савалгаанд" өртөлгүй таатай орчинд амьдарна.

Хоёрдугаарт: Монгол улс гадаад харилцаагаа зөвхөн босоо тэнхлэгээр бус "босоо, хэвтээ" тэнхлэгийн аль алиныг тэнцүүлж байж сая хөгжинө.

Гутгаарт: Бид бүс нутгийн интеграцчилалд орж, улмаар "globalization" буюу "даяаршил"-д хамрагдах нь чухал.

Mongolia has two neighbors: Russia and China physically. By the international relations theory "nation", "nation state", "state", "international organizations" and "transnational corporations" might be an international actor. So in reality none of those the Mongolian third neighbor. But in possible future they could be a strategic partner of Mongolia.

⁵ Ibid